



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эко стар ХХК-ийн “Эко стар” зочид буудлын 17/196, Ичмон трэйвел ХХК-ийн “Ичмон” зочид буудлын 17/155, Оюуны аав ХХК-ийн “Агора” зочид буудлын 17/183, Проджи ХХК-ийн “Атлас” зочид буудлын 17/199, Би ди би си ХХК-ийн “Ану-марал” зочид буудлын 17/171, Кома юнайтед инк ХХК-ийн “Гүүд дэй” зочид буудлын 18/205, Төгөл гоо ХХК-ийн “Бурхант төв” зочид буудлын 17/208, Зүүн баян рефайнери ХХК-ийн “Пийс бридж” зочид буудлын 17/190, Булгат мөрөн ХХК-ийн “Роял моунтайн” зочид буудлыг 17/242, Сэрүүлэг констракшн ХХК-ийн “БТ” зочид буудлын 17/118, Оасисмон ХХК-ийн “Оасисмон” дэн буудлын 17/213, Манкур ХХК-ийн “Манкур” дэн буудлын 17/206 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

1150500253

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 09
сарын 26 өдрийн А/77 дугаар
тушаалын нэгдүгээр хэвсрэлт

5284325 СБТ-8936 1118263602

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.09.26

Улаанбаатар хот

Д/ д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эко стар ХХК	5088275	Эко стар	СБД-ийн 8-р хороо Бага тойруу 46-4
2	Ичмон трэйвел ХХК	6144608	Ичмон	БЗД-ийн 3-р хороо 12-р хороолол, Токиогийн гудамж 24-3
3	Оюуны аав ХХК	5299691	Агора	БЗД-ийн 16-р хороо Улаанхуаран гудамж 80
4	Проджи ХХК	5197406	Атлас	ХУД-ийн 10-р хороо морингийн даваа
5	Би ди би си ХХК	5381738	Ану-марал	БГД-ийн 9-р хороо 3-р хороолол Хасбаатарын 22
6	Кома юнайтед инк ХХК	2772515	Гүүд дэй	БГД-ийн 8-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж 14
7	Төгөл гоо	5528658	Бурхант төв	БГД-ийн 22-р хороо 3-р хороолол 61
8	Зүүн баян рефайнери ХХК	2637634	Пийс бридж	ХУД-ийн 1-р хороо Чингисийн өргөн чөлөө, дунд гол 47
9	Булгат мөрөн ХХК	2018632	Роял моунтайн	ХУД-ийн 3-р хороо Чингисийн өргөн чөлөө Шаравын гудамж 6
10	Сэрүүлэг констракшн ХХК	2573091	БТ	СБД-ийн 1-р хороо Чингисийн өргөн чөлөө 106

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 09
сарын 26 өдрийн А/77 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

628025 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.09.26

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Оасисмон ХХК	5678714	Оасисмон	БЗД-ийн 12-р хороо чулуутын 1-10
2	Манкур ХХК	2881039	Манкур	БГД-ийн 16-р хороо Туулын 19-386
3	Хотол ивээлт ХХК	5650539	Би экс	БЗД-ийн 5-р хороо Өлгийн 30-395Б
4	Уянга уул ХХК	2568187	Уянга	СБД-ийн 10-р хороо 82-2
5	Баянжисрэгт ХХК	2686709	Би жи	БЗД-ийн 16-р хороо 16-р хороолол 38-01
6	Есөн гарьд ХХК	2099667	Онон	БЗД-ийн 5-р хороо Өлгийн 31-408
7	Усанлянхуа ХХК	5546818	Норпэл	БГД-ийн 4-р хороо 4-р байр 3-4 тоот
8	Элкс трейд ХХК	2110318	Элкс	ХУД-ийн 3-р хороо Чингисийн өргөн чөлөө